


**GOBI**

MONGOLIAN CASHMERE



ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ

ЖИЛИЙН  
ТАЙЛАН 2019



# АГУУЛГА

5-15

## МАНАЙ КОМПАНИ

Компанийн ерөнхий танилцуулга  
Бизнес модель/Бидний үнэ цэнэ  
Түүхэн замнал  
ТУЗ-ийн даргын мэндчилгээ  
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ  
Стратеги болон үйл ажиллагааны өөрчлөлт

17-25

## 2019 ОНД БИД

Бидний амжилтууд  
Говь ХК 2019 онд  
2019 оны санхүүгийн үр дүн  
Хөрөнгө оруулалт  
Төсөвт төвлөрүүлсэн татвар хураамж

27-59

## БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ноолуурын салбар  
Дотоод зах зээл  
Гадаад зах зээл  
Онлайн худалдаа  
Брэндүүд  
Коллекцууд  
Бидний харилцагчид

61-83

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Засаглалын бүтэц, үйл ажиллагаа  
Засаглалын өөрийн үнэлгээ  
Хувьцаа эзэмшигчид  
Хувьцаа эзэмшигчдийн хурал  
Төлөөлөн удирдах зөвлөл  
Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн  
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайлан  
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны хурлын мэдээлэл  
Дотоод аудитын хэлтэс  
Дотоод хяналтын тогтолцоо  
Эрсдэлийн удирдлага  
Компанийн бүтэц  
Компанийн эрх бүхий албан тушаалтнууд  
Хөрөнгийн зах зээл ба компанийн хувьцаа  
Ногдол ашиг


85-91

## ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Тогтвортой хөгжил 2019 онд  
2019 онд тогтвортой хөгжлийн хүрээнд хийгдсэн онцлох ажлууд  
ISO стандарт  
Байгаль орчны бодлого  
Нийгмийн хариуцлага  
Чанарын удирдлага

93-100

## ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУДЫН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН



МАНАЙ  
КОМПАНИ



## КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

<b>Компанийн оноосон нэр:</b>	ГОВЬ хувьцаат компани
<b>Үйл ажиллагааны чиглэл:</b>	Ямааны ноолууранд цогц боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах
<b>Компанийн албан ёсны хаяг:</b>	Монгол улс, Улаанбаатар хот-17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК  Шуудангийн хаяг: Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг 36/434, Говь ХК Утас: (976)-70139977 Факс: (976)-70143081 И-мэйл: info@gobi.mn Вэб сайт: www.gobi.mn Фэйсбүүк: GobiCashmere Онлайн дэлгүүр: www.gobicashmere.com www.us.gobicashmere.com www.de.gobicashmere.com www.gobicashmere.world.taobao.com
<b>Компанийн удирдлага:</b>	ТУЗ-ийн дарга: Дамбын ГЭРЭЛМАА Гүйцэтгэх захирал: Цагаачийн БААТАРСАЙХАН
<b>Үүсгэн байгуулагдсан огноо:</b>	1981 оны 9 сарын 5-ны өдөр
<b>Ажилчдын тоо:</b>	2,612
<b>Үйлдвэрийн хүчин чадал:</b>	1,100 тонн түүхий ноолуур боловсруулах 820 тонн ээрмэл болон нарийн ээрмэл утас хийх 1,500,000 ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх 1,000,000 метр нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх 162,000 ширхэг ноолууран пальто болон пиджак үйлдвэрлэх
<b>Дэлгүүрийн тоо:</b>	Дотоод Улаанбаатар хот 5 Дархан хот 1  Гадаад Цахим дэлгүүр 3 Салбар дэлгүүр 4 Франчайз дэлгүүр 53

# БИЗНЕС МОДЕЛЬ БИДНИЙ ҮНЭ ЦЭНЭ

## САНХҮҮГИЙН НӨӨЦ

Хувьцаа эзэмшигчид, дотоод, гадаадын банк санхүүгийн байгууллага болон үйл ажиллагаанаас эх үүсвэртэй шаардлагатай санхүүжилт (зээл, баталгаа...)

## ХҮНИЙ НӨӨЦ

Бидний гол нөөцийн нэг болох ажилтнуудын ур чадвар, мэдлэг туршлага нь хүний нөөцийн хөгжлөөр нэмүү өртөг үүсгэх гол боломж болно

## ҮЙЛДВЭРИЙН НӨӨЦ

Говь ХК-ийн бүтээгдэхүүн үйлчилгээ хүргүүлэхэд шаардлагатай үйлдвэрлэлийн зориулалт бүхий биет материал болон хөрөнгө

## ОЮУНЫ НӨӨЦ

Бидний ирээдүйн орлогын баталгаа, өрсөлдөх хүч болсон оюуны өмч, брэнд болон нэр хүнд

## БАЙГАЛИЙН НӨӨЦ

Бидний ирээдүйн сайн сайхны үр үндэс болох байгалийн нөөц баялаг (түүхий ноолуур, ус, агаар, хөрс, бүтээгдэхүүн зэргийн эрүүл байдал)

## НИЙГЭМ, ХАРИЛЦААНЫ НӨӨЦ

Говь ХК-ийн оролцогч талуудтай үүсэх харилцаа нь компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлын баталгаа болно

## БИДНИЙ ЗОРИЛТ

Говь ХК нь хүний хөгжил, технологиор тэргүүлэн, хэрэглэгч, харилцагчдын сэтгэл ханамжийг хамгийн өндөрт хүргэж, хөрөнгө оруулагч, ажилтнуудын үнэ цэнэтэй байгууллага байна

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ


Шударга, ил тод, нээлттэй

Хууль, дүрмийг чандлан сахиулна


Хүний эрхийг дээдэлнэ

Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлнэ

Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулна



# ТҮҮХЭН ЗАМНАЛ





## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Говь ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны үр дүн, амжилт ололт болон цаашид сайжруулан хөгжүүлэх ажлуудаа тайлагнах хариуцлагатай цаг ирлээ.

Улиран өнгөрсөн жилд ТУЗ, гүйцэтгэх удирдлагын баг болон ажилтнуудынхаа хамтын хүчин чармайлтаар Говь ХК Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “ТОП-100” ААН-ийн 18 дугаар байранд шалгарч, мөн Монголын гарал үүсэлтэй 100% ноолуураар үйлдвэрлэгдсэн, дэлхийн стандартад нийцсэн, байгальд ээлтэй технологиор үйлдвэрлэгдсэн, өндөр чанартай бүтээгдэхүүн гэдгийг гэрчлэх “МОНГОЛЫН ХААН ШИРХЭГТ” тохирлын гэрчилгээг авлаа.

Бид сайн засаглалын зарчмууд, үйлдвэрлэлийн өндөр бүтээмж үр ашигт байдал, тогтвортой хөгжлийн стратегийг чиг болгон ажилласан бөгөөд Говь ХК 2019 онд 2.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж компанийн зах зээлийн үнэлгээ 210.6 тэрбум төгрөгт хүрсэн байна.

2019 онд бид үйл ажиллагаагаа өргөтгөх, гадаад зах зээлд өрсөлдөх байр сууриа улам бататгах зорилготой ажиллаж томоохон хэмжээний хөрөнгө оруулалтуудыг хийхийг голчлон үзсэний үр дүнд компани ажиллах хүч болоод техник тоног төхөөрөмжийн хувьд улам өргөжиж чадлаа.

Бид Гоёо ХХК-ийг өөртөө нэгтгэн авч том нэгдлийг амжилттай гүйцэтгэж, олон улс дахь онлайн худалдааны зах зээл, сувгуудыг улам хөгжүүлэхээр зорьсон нь оновчтой шийдвэрүүд байсан гэж дүгнэж байна.

Энэ завшааныг ашиглан 2019 онд дэвшүүлсэн зорилго зорилтдоо хүрэхийн тулд хичээл зүтгэлтэй, бүтээлч ажилласан компанийн удирдлагууд болон нийт ажиллагсдадаа талархал илэрхийлье!

Та бүхэнд өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  
Д.ГЭРЭЛМАА



## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, бизнесийн түнш, хамтран ажиллагсад та бүхэндээ чин сэтгэлийн халуун мэндчилгээ дэвшүүлье.

“Дэлхийд танигдсан Монгол брэнд” уриатай Говь ХК нь 1981 оноос төрийн өмчит үйлдвэрийн газар хэлбэрээр үүсгэн байгуулагдаж, 2007 онд хувьчлагдсан ба нийт 17,000 гаруй хувьцаа эзэмшигчидтэй, Монгол улсынхаа эдийн засаг, хөнгөн үйлдвэрлэлийн салбарын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсаар ирсэн үндэсний томоохон үйлдвэрийн нэг юм. Үүсгэн байгуулагдсан цагаас хойш ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл, гадаад, дотоод худалдааны чиглэлтэйгээр үйл ажиллагаагаа өнөөдрийг хүртэл амжилттайгаар тасралтгүй явуулж байгаа бөгөөд түүхэн энэ жилүүдэд байгууллагын маань үе үеийн удирдлага, ажилчид, хамт олны хүчин зүтгэл, хөдөлмөрийн үр дүнд улам бүр өргөжин тэлж, улсдаа татвар төлөлт, ажиллах хүчээрээ тэргүүлэх 20 компанийн нэг болоод байгааг цохон тэмдэглэхэд таатай байна.

Өнгөрсөн 2019 онд 39 жилийн туршлагатай Говь ХК нь Монгол ноолуураар дэлхийг гоёж, дэлхийн ноолууран хувцасны зах зээлд тэргүүлэгч болох эрхэм зорилгын дор 27 жилийн түүхтэй Гоёо ХХК-ийн хувьцааг 100% худалдан авч, улмаар 600 гаруй чадварлаг хүний нөөц, орчин үеийн дэвшилтэд технологи, загварын шинэлэг өнгө төрхийг нэгтгэж чадсан билээ.

Бидний хувьд нэгдлийн үе шат бүхэнд онцгой анхаарч ажилчдынхаа өмнө хүлээх хариуцлагаа ухамсарлан цомхотгол огт хийлгүйгээр, амжилттай нэгдэх үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд хоёр компани нэгдсэнээр үйлдвэрийн хүчин чадал жилд 1,100 тонн ноолуур, 820 тонн ээрмэл утас, 1,500,000 ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн, 162,000 ширхэг оёмол бүтээгдэхүүн, 1,000,000 метр даавуу, драп, нэхмэл бүтээгдэхүүн болж өслөө. Мөн бид үйлдвэрийн хүчин чадал болон анхан шатнаас эхлэн эцсийн бэлэн бүтээгдэхүүн хүртэлх бүхий л дамжлагыг 100% өөрсдөө хийдэг онцлогоороо Дэлхийд №2-т, ажилчдын тоогоор Монгол улсдаа №4-т эрэмбэлэгдэх боллоо.

Нэгдэл хийсэн бидний туйлын зорилго бол цаашид олон улсад өрсөлдөхүйц, хүлээн зөвшөөрөгдсөн компани болох явдал юм. Хурдацтай хөгжиж буй техник технологийн хөгжлийг даган дэлхий дахинд онлайн худалдаа эрчимтэй хөгжиж байгаатай холбоотойгоор 2019 оны 7 сараас эхлэн онлайн худалдаанд илүү анхаарлаа хандуулан ажиллаж эхэлсэн. Дэлхийн зах зээлд бараа бүтээгдэхүүнээ илүү таниулж борлуулах үүднээс АНУ-н Лос Анжелес хотод охин компаниа байгуулсан. 2019 оны 2-р хагаст онлайн борлуулалтад анхаарч стратеги төлөвлөгөөг боловсруулан, маркетингийн идэвхжүүлэлтийг идэвхтэй тасралтгүй хийсний үр дүнд онлайн сувгаар 19 мянган ширхэг бүтээгдэхүүн буюу 1.7 сая ам.долларын борлуулалттай байна.

2019 онд бид 346.5 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй, жилд 210 тэрбум төгрөгийн борлуулалт, 2,600 гаруй хүнийг ажлын байраар хангаж, улсын төсөвт 34 гаруй тэрбум төгрөгийн татвар, хураамж төвлөрүүлсэн үндэсний хэмжээний томоохон компани болоод байна.

Миний бие тус компанийн гүйцэтгэх захирлын хувиар Говь ХК-ийг зах зээлд тэргүүлэгчийн байр сууриа хадгалж, улс орныхоо эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулах ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ, ХАРИЛЦАГЧ, ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, АЖИЛТНУУДЫНХАА САЙН САЙХНЫ ТӨЛӨӨ хөнгөн үйлдвэрлэлийн салбарын жишиг компани байлгахыг эрхэм зорилго болгон ажиллах болно.

Бидний ололт амжилтыг цаг үргэлж дэмжиж байдаг та бүхэндээ сайн сайхныг хүсэж, цаашдын ажил үйлст тань өндрөөс өндөр амжилт хүсэн ерөөе.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Ц.БААТАРСАЙХАН



## СТРАТЕГИ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨӨРЧЛӨЛТ

2019 онд Говь ХК нь Гоёо ХХК-ийг нэгтгэн авснаар салбарын хамгийн том нэгдлийг амжилттай гүйцэтгэлээ. Тус нэгдлийг хэрэгжүүлэхдээ бид дараах зорилго, зарчмыг үндэслэн ажилласан билээ.

### СТРАТЕГИ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨӨРЧЛӨЛТ

#### НЭГДЛИЙН ЗОРИЛГО

- Монгол улсын Ноолуурын салбарын тэргүүлэх аж ахуйн нэгжийн байр сууриа бэхжүүлэх
- Олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг өсгөх, сайжруулах
- Компанийн үр ашгийг нэмэгдүүлэх
- Оролцогч талуудын эрх ашгийг хамгаалан, төгөлдөржүүлэх

#### МӨРДСӨН ЗАРЧИМ

- Нэгдлээс үүдэн гарах шинэ боломжийг бүтэц зохион байгуулалтад оновчтой хуваарилах
- Бизнесийн үнэ цэнэ, өгөөжийг тогтворжуулах, улмаар нэмэгдүүлэх
- Зах зээлийн эрүүл өрсөлдөөнийг баримтлан, дэмжих
- Нийгмийн хариуцлагатай, тогтвортой хөгжлийн зорилтыг эрхэмлэх

Салбарын тэргүүлэгч компанийн хувьд Говь ХК нь тус нэгдлийн үйл ажиллагааг бие даан гүйцэтгэсэн бөгөөд өнгөрөгч хагас жилийн хугацаанд дараах асуудлуудыг нэн тэргүүнд тавин шийдвэрлэн ажиллалаа.

#### Хүний нөөц

- Өөрчлөлттэй холбоотой шинэ бүтэц зохион байгуулалт
- Хүний нөөцийн нэгдсэн бодлого

#### Брэндийн үнэ цэнэ


- Шинэ брэндийн үнэ цэнийг шингээн авах
- Холбогдох өгөөжийг нэмэгдүүлэх

#### Бусад үйл ажиллагаа

- Шинэ уялдаа холбоог үүсгэх
- Үйлдвэрлэлийн шинэ зохион байгуулалт



2019  
ОНД БИД



## БИДНИЙ АМЖИЛТУУД



### ТОП-100 АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА

2019 оны 05 сарын 16-ны өдөр Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "ТОП-100" ААН-ийг шалгаруулах ёслол болж, Говь ХК 18 дугаар байранд шалгарлаа.










### ГОВЬ ХК "МОНГОЛЫН ХААН ШИРХЭГТ" ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭТЭЙ БОЛЛОО.

"Монголын Хаан Ширхэгт" тохирлын тэмдэг нь тухайн ноос, ноолуураар үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн нь тогтоосон стандарт шаардлагыг бүрэн хангасан, Монголын гарал үүсэлтэй 100% ноолуураар үйлдвэрлэгдсэн, дэлхийн стандартад нийцсэн, байгальд ээлтэй үйлдвэрлэлээр үйлдвэрлэгдсэн, өндөр чанартай бүтээгдэхүүн гэдгийг гэрчлэх бөгөөд ноос, ноолууран бүтээгдэхүүний гарал үүслийн ба чанарын баталгаа болно.


Бид самнасан ноолуур, болон сүлжмэл цамц дээр "МОНГОЛЫН ХААН ШИРХЭГТ" тохирлын гэрчилгээг авсан нь чанар, стандартын шаардлага хангасан, өндөр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг батлан харуулж байна. Мөн тус тохирлын тэмдэг нь Говь брэндийн бүтээгдэхүүн нь амьтанд ээлтэй, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөргөөр нөлөөлөхгүй, байгальд ээлтэй технологиор үйлдвэрлэгдсэнийг гэрчилнэ. Гэрчилгээ нь нэг жилийн хугацаанд хүчинтэй ба жил бүр Монголын ноос ноолуурын холбооноос Чанарын хяналтын тогтолцоонд аудит хийлгэн баталгаажуулалт авах юм.

# ГОВЬ ХК 2019 ОНД


/2018 оны гүйцэтгэлтэй харьцуулав/




## НИЙТ АЖИЛТНУУДЫН ТОО 2,612



### АЖИЛТНУУДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА



### АЖИЛТНУУДЫН НАСЖИЛТ



### АЖИЛТНУУДЫН АЛБАН ТУШААЛЫН ТОО-284



### БОЛОВСРОЛЫН ТҮВШИН






## 2019 ОНЫ САНХҮҮГИЙН ҮР ДҮН


ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	2018 он	2019 он	Өмнөх оноос өсөлт	
		Гүйцэтгэл (Аудитлагдсан)	Гүйцэтгэл (Аудитлагдаагүй)	тоо	хувь
<b>БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО</b>	<b>сая.төг</b>	<b>173,439</b>	<b>209,748</b>	<b>36,309</b>	<b>21%</b>
Үүнээс: Дотоод борлуулалт	сая.төг	111,864	134,759	22,895	20%
Гадаад борлуулалт	сая.төг	61,575	74,989	13,414	22%
Экспорт	мян.USD	24,713	28,109	3,396	14%
<b>БОРЛУУЛСАНБҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ</b>	<b>сая.төг</b>	<b>102,148</b>	<b>141,952</b>	<b>39,804</b>	<b>39%</b>
<b>НИЙТ АШИГ</b>	<b>сая.төг</b>	<b>71,292</b>	<b>67,796</b>	<b>-3,496</b>	<b>-5%</b>
Үйл ажиллагааны зардал	сая.төг	41,852	59,848	17,996	43%
Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	6,191	3,861	-2,330	-38%
Татварын өмнөх ашиг	сая.төг	23,248	4,087	-19,161	-82%
<b>ЦЭВЭР АШИГ</b>	<b>сая.төг</b>	<b>17,764</b>	<b>2,456</b>	<b>-15,308</b>	<b>-86%</b>
Нийт үйл ажиллагааны зардал	сая.төг	144,000	201,800	57,800	40%
Орлогын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	0.83	0.96	0.13	16%
<b>ҮЙЛДВЭРЛЭЛТ</b>					
Сүлжмэл	мян.шир	800	972	172	22%
Нэхмэл	мян.шир	478	415	-63	-13%
Оёмол	мян.шир	82	80	-2	-3%
Үүнээс: Пальто	мян.шир	56	48	-8	-14%
Пиджак	мян.шир	8	9	1	11%
Ээрмэл	тонн	367	275	-92	-25%
<b>АЖИЛТНУУДЫН ТОО</b>	<b>хүн</b>	<b>2,113</b>	<b>2,612</b>	<b>499</b>	<b>24%</b>
Нэг ажилтанд ногдох орлого	мян.төг	82,082	80,302	-1,780	-2%
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	<b>сая.төг</b>	<b>29,476</b>	<b>60,517</b>	<b>31,041</b>	<b>105%</b>

# ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2007 оноос хойш нийт хөрөнгө оруулалт 147 тэрбум төгрөг





2007 оны хувьчлалаас хойш өссөн дүнгээрээ нийт 147 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Үүнээс 2019 онд 60 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 23 тэрбум нь барилга байгууламж, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгө оруулалтад зарцуулагдсан бөгөөд дотор нь задалж үзвэл 1.4 тэрбум төгрөг буюу 6.1%-ийг барилга байгууламжийн бүтээн байгуулалт, 21.0 тэрбум төгрөг буюу 91%-ийг үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, 671 сая төгрөг буюу 2.9%-ийг бусад хөрөнгө оруулалтад зориулсан байна. Харин нэгтгэлийн хөрөнгө оруулалтад 37 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.



## ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР ХУРААМЖ

- Нэмэгдсэн өртгийн албан татвар
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
- Нийгмийн даатгалын шимтгэл
- Хүн амын орлогын албан татвар
- Гаалийн татвар
- Үл хөдлөх хөрөнгийн албан татвар
- Газрын татвар
- Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар





БИДНИЙ  
ҮЙЛ  
АЖИЛЛАГАА

# НООЛУУРЫН САЛБАР


## САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ /Монгол/

Монгол улсад 2019 онд 29.3 сая тоо толгой ямаан сүрэг тоологдсон нь өмнөх онтой ижил үзүүлэлттэй байлаа. Манай улс 2019 онд 11,000 орчим тонн ноолуур бэлтгэсэн нь өмнөх оноос 0.4% өсөлттэй байсан бөгөөд дэлхийн түүхий ноолуурын 40%-ийг хангаж байна. Харин ноолуурын дундаж үнэ 111,700 төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 20.6% өссөн үзүүлэлттэй байсан.



Сүүлийн 5 жилийн Монгол улсын ноолуурын салбарын тоон мэдээлэл:


Монгол улсын ямааны тоо толгой



Монгол улсын түүхий ноолуур бэлтгэл



Түүхий эдийн дундаж үнэ



Монгол улсын Ноолуурын зах зээл





## “НООЛУУР ХӨТӨЛБӨР 2018-2021”

Засгийн газрын 2000 оны 114 дүгээр тогтоолоор анх баталсан “Ноолуур” хөтөлбөрийг 2000-2004 онд хэрэгжүүлсний үр дүнд ноолууран эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт эрчимтэй өсч, тухайн үеийн эдийн засаг, нийгмийн хөгжилд чухал хувь нэмрийг оруулсан.

Тус хөтөлбөрийн үргэлжлэл болох “Ноолуур хөтөлбөр 2018-2021”-г Монгол улсын ноолуурын салбарын цаашдын хөгжлийг дэмжих үүднээс Засгийн газрын 2018 оны 47 дугаар тогтоолоор батлуулсан.

### • Хөтөлбөрийн зорилго

Ноолуурын бүрэн боловсруулалтын түвшинг 60 хувьд хүргэж, байгаль орчинд ээлтэй эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлж, ноолууран бүтээгдэхүүний олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх.

### • Хөтөлбөрийн зорилтууд

Зорилт 1. Эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд шаардлагатай эрх зүй, хөрөнгө оруулалт, татварын таатай, тогтвортой орчинг бүрдүүлэх

Зорилт 2. Ямааны үүлдэр угсаа болон түүхий эдийн бэлтгэл, ноолуурын чанарыг сайжруулах

Зорилт 3. Ноолуурын бүрэн боловсруулалтын түвшнийг үе шаттай ахиулж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх

Зорилт 4. Байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, зорилтот зах зээлд чиглэсэн ээлтэй, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнийг хөгжүүлэх

Зорилт 5. Салбарын хүний нөөцийг эрэлт, шаардлагад тулгуурлан сургаж, мэргэшүүлэх замаар үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх.

### • Хэрэгжүүлэх үе шат

Нэгдүгээр үе шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (2018-2019 онд): Нийт түүхий эдийн 40 хувийг дотоодын үйлдвэрийн хэрэгцээнд авч, ноолуурын үйлдвэрлэл, худалдаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийг боловсронгуй болгох, аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн оновчтой дэмжлэг үзүүлэх замаар үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, бүрэн боловсруулалтын түвшинг ахиулах, кластерыг дэмжих, брэндийг таниулах, түүхий эдийн чанар, бэлтгэлийн тогтолцоог сайжруулна.

Хоёр дугаар үе шатны хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (2020-2021 онд): Нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилгод хүрэх, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжид олгох хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалтын дэмжлэгийн нөхцөлийг сайжруулан, татвар, санхүүгийн оновчтой дэмжлэг үзүүлснээр түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшинг 60 хувьд хүргэж, ноолуурын салбарт одоо байгаа 5,000 гаруй ажлын байрыг тогтвортой хадгалж, 3,600 гаруй ажлын байрыг шинээр бий болгон, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын хэмжээг 5.7 дахин өсгөх зэрэг эерэг үр дүн гарах боломжтой.

ҮЗҮҮЛЭЛТ	Суурь түвшин 2017 он	Гүйцэтгэл 2018 он	Зорилтот түвшин 2021 он
Угаасан ноолуурын экспорт (тонн)	5,409.7	5,286.6	2,632
Самнасан ноолуурын экспорт (тонн)	571.4	630.2	1,579
Сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлт (мян.ш)	915.6	932.5	2,200
Байнгын ажлын байрны тоо (хүн)	5,582	7,126	9,110




# ДОТООД ЗАХ ЗЭЭЛ

ДОТООД ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ

# ↑20%

2019 онд дотоод борлуулалт 135 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 20% өсөлттэй байсан. Энэ нь Монгол Улсын ноолууран бэлэн бүтээгдэхүүний зах зээлийн 83%-ийг эзэлж байна.



## ХУДАЛДАН АВАГЧИД

Дотоод борлуулалтыг мөнгөн дүнгээр аваад үзвэл 51%-г Монгол худалдан авагчид, харин 49%-г гадаад худалдан авагчид буюу жуулчдын худалдан авалт эзэлж байна. Говь ХК-с худалдан авалт хийсэн нийт жуулчдын 49%-г Солонгос болон Хятад улсын жуулчид, Европын бусад орнууд 16%-г, Азийн бусад орнууд 28%-г эзэлж байна.



# ↑9%

МОНГОЛ УЛСАД ИРСЭН  
НИЙТ ЖУУЛЧИД  
577 мянган хүн

# ↑27%

ГОВЬ БРЭНДИЙН ДЭЛГҮҮРЭЭР  
ҮЙЛЧЛҮҮЛСЭН ЖУУЛЧИД  
379 мянган хүн

# ↑10%

ЖУУЛЧДЫН ХУДАЛДАН  
АВАЛТЫН ДҮН  
67 тэрбум төгрөг

2019 онд Монгол улсад зочилсон нийт жуулчдын тоо өмнөх оноос 9% өсөж, 577 мянгад хүрсэн. Үүнээс 66 орчим хувь нь Говь ХК-ийн нэрийн дэлгүүрээр үйлчлүүлсэн байгаа нь бүтээгдэхүүн худалдан авсан гадаад жуулчдын тоо 27% өссөн. Энэхүү татах хүчийг даган жуулчдын худалдан авалтын дүн 10% өссөн байна.



## ГОВЬ БОЛОН ГОЁО-ЫН ХАМГИЙН ТОМ НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ “OUTLET” ДЭЛГҮҮР

2019 оны 6 сард Гоёо ХХК-ийн үйлдвэрийн дэргэдэх дэлгүүрийг Gobi, Goyo, Yama, Gobi Organic, Gobi Kids брэндүүдийн хамгийн өргөн сонголт бүхий Ноолууран Бүтээгдэхүүний Хямдралын Дэлгүүр болгон дахин нээв. Улмаар байнгын хямдрал, урамшуулалтай бүтээгдэхүүнээр хэрэглэгчиддээ үйлчилж эхэллээ.



## НООЛУУРАН ПАЛЬТО БОЛОН ХОСЛОЛЫН ХАМГИЙН ТОМ ТАСАГ “ГАЛЛЕРИА УЛААНБААТАР” САЛБАР

2019 оны 6 сард Галлериа Улаанбаатар дэлгүүрийн тасгийн өөрчлөлт зохион байгуулалтыг хийж, зөвхөн ноолууран пальто болон хослолын тасгийг нээн, хэрэглэгч нарт илүү тав тухыг мэдрүүлж чадсан.

## 2020 ОНД

Борлуулалтын сувгуудынхаа үр ашгийн тооцооллыг хийсний үндсэн дээр цаашид Үйлдвэрийн дэргэдэх төв дэлгүүр, Галлериа Улаанбаатар дэлгүүр, "Outlet" дэлгүүр, Смарт салбар дэлгүүр, Чингис хаан ОУНОБ салбар дэлгүүр, Дархан салбар дэлгүүр гэсэн үндсэн 6 салбар дэлгүүрээр борлуулалтыг хийхээр төлөвлөж байна.



ҮЙЛДВЭРИЙН ДЭРГЭДЭХ  
ТӨВ ДЭЛГҮҮР



ГАЛЛЕРИА УЛААНБААТАР  
САЛБАР ДЭЛГҮҮР



СМАРТ САЛБАР ДЭЛГҮҮР




OUTLET ДЭЛГҮҮР



ЧИНГИС ХААН ОУНОБ  
ДЭЛГҮҮР



ДАРХАН САЛБАР  
ДЭЛГҮҮР



# THE WORLD'S LARGEST CASHMERE STORE


GOBI GALLERIA ULAANBAATAR

# ГАДААД ЗАХ ЗЭЭЛ

## МОНГОЛ УЛСААС ЭКСПОРТЫН ЗАХ ЗЭЭЛД

↑ 22%

2019 онд гадаад борлуулалт 75 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 22% өсөлттэй байсан. Энэ нь Монгол улсаас экспортын зах зээлд 74.2%-ийг эзэлж байна.



Бид дэлхийн 28 орны 171 орчим харилцагч нарт бүтээгдэхүүнээ нийлүүлж байна. 2019 оны сүүлийн байдлаар 12 улсын 37 хотод 53 франчайз дэлгүүр, 4 салбар дэлгүүр, 3 охин компанитай байна.

## ШИНЭЭР НЭЭГДСЭН ФРАНЧАЙЗ ДЭЛГҮҮРҮҮД



ХОНКОНГ-Д  
1 САРД



САН ФРАНЦИСКО ХОТОД  
2 САРД



ОХУ-ЫН ТЫВА ХОТОД  
6 САРД

## АНУ-ЫН ЛОС АНЖЕЛЕС ХОТОД ОХИН КОМПАНИЙГ БАЙГУУЛСАН.


АНУ-ын онлайн зах зээлд өөрсдийн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах зорилгоор АНУ дахь ГОВЬ ХК-ийн охин компанийг байгуулав.



# ОНЛАЙН ЗАХ ЗЭЭЛ



[www.gobicashmere.com](http://www.gobicashmere.com)  
[www.us.gobicashmere.com](http://www.us.gobicashmere.com)  
[www.de.gobicashmere.com](http://www.de.gobicashmere.com)  
[www.gobicashmere.world.taobao.com](http://www.gobicashmere.world.taobao.com)



## ОНЛАЙН ХУДАЛДАА

Говь ХК нь дэлхийн олон улс оронд өөрийн салбар дэлгүүр болон франчайз дэлгүүрээр дамжуулан бараа бүтээгдэхүүнээ борлуулдаг. Мөн үүний хажуугаар онлайн сувгаар дамжуулан бараа бүтээгдэхүүнээ дэлхийн зах зээлд борлуулж ирсэн бөгөөд 2019 оны 7 сараас эхлэн онлайн худалдаанд илүү анхаарлаа хандуулан ажиллаж эхэлсэн. Хурдацтай хөгжиж буй техник технологийн хөгжлийг даган дэлхий дахинд онлайн худалдаа эрчимтэй хөгжиж байна. Онлайн худалдаа нь хэрэглэгчдийн цаг завьг хэмнэхээс гадна, төлбөрийн уян хатан нөхцөл, хүргэлт, буцаалтыг богино хугацаанд хийдгээрээ давуу талтай юм.

Бидний зорилтот гурван том зах зээлд нийт 2.9 тэрбум хүн оршин суудаг бөгөөд Монгол улстай харьцуулахад худалдан авах чадвар илүү өндөр байна. Иймд энэ зах зээлд хүрч ажиллах үүднээс бид цаашид "Online" борлуулалтын сувгаа илүү хөгжүүлэн тэлэх бодлогыг баримталж ажиллана.



2019 онд Говь брэнд гадаад дахь 3 охин компаниар дамжуулан онлайн борлуулалтыг хийсэн. Дараах 3 улсын хотуудаар дамжуулан өөрсдийн бараа бүтээгдэхүүнийг дэлхийн өнцөг булан бүрд хүргэх зорилготойгоор ажилласан.



### GOBICASHMERE.COM

232 загвар худалдаалж байна.

1.4 сая орчим хүнд өдөр бүр сурталчилгаа хүрсэн.

54% гар утас, 29% таблет, 17% компьютер ашигласан.

Өдөр бүр 7,800 гаран хүн орж ирсэнээс Эмэгтэй 66%, Эрэгтэй 34%



### US.GOBICASHMERE.COM

157 загвар худалдаалж байна.

1.2 сая орчим хүнд өдөр бүр сурталчилгаа хүрсэн.

39% гар утас, 27% таблет, 34% компьютер ашигласан.

Өдөр бүр 4,800 гаран хүн орж ирсэнээс Эмэгтэй 61%, Эрэгтэй 31%



### GOBICASHMERE.TAOBAO.COM

178 загвар худалдаалж байна.

1.2 сая орчим хүнд өдөр бүр сурталчилгаа хүрсэн.

93% гар утас, таблет, компьютер ашигласан.

Өдөр бүр 3,500 гаран хүн орж ирсэнээс Эмэгтэй 67%, Эрэгтэй 33%




## БОРЛУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ

2019 оны 7 дугаар сараас онлайн маркетинг идэвхжүүлэлт эрчимтэй хийгдсэний үр дүнд мөн үеийн борлуулалтаа 9 дахин өсгөв.



## 2019 ОНЫ БОРЛУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ САРААР

Борлуулалтын орлого /сая төгрөг/



БЕРЛИН салбараас Европын бүх улсууд болон дэлхийн бусад орнууд руу хүргэлтийн үйлчилгээг хийдэг.

“Говь” ХК нь герман хэлтэй улсууд болох Герман, Австри, Швейцарь, Люксембург, Лихтенштейн, Бельги хэрэглэгчдэдээ зориулсан онлайн дэлгүүрийг 12 дугаар сарын 6-нд албан ёсоор нээлээ. <https://de.gobicashmere.com/>



Дэлхийн ноолууран бүтээгдэхүүний жижиглэнгийн борлуулалтын 17% Европ-д хийгдэж байна




## БОРЛУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ

2019 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр онлайн худалдаа хийгдэж эхэлсэн.



## 2019 ОНЫ БОРЛУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ САРААР

Борлуулалтын орлого /сая төгрөг/



ЛОС АНЖЕЛЕС дахь салбараас АНУ-н бүх муж хотууд болон Канадын бүх хот руу хүргэлтийн үйлчилгээг хийдэг.

“Говь” ХК-ийн АНУ дахь онлайн дэлгүүрийг <https://us.gobicashmere.com/> 2019 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр нээлээ



Дэлхийн ноолууран бүтээгдэхүүний жижиглэнгийн борлуулалтын 18% АНУ-д хийгдэж байна.



GOBICASHMERE.TAOBAO.COM


## БОРЛУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ

2019 оны 3-р улирлаас эхлэн Хятадын онлайн худалдааны ТАОБАО сувагт анхаарч эхэлснээр борлуулалт өнгөрсөн оноос 3 дахин өсөв.



## 2019 ОНЫ БОРЛУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ САРААР

Борлуулалтын орлого /сая төгрөг/



ЭРЭЭН салбараас БНХАУ-н бүх хот руу хүргэлтийн үйлчилгээг хийдэг.

2019 оны 12 сараас эхлэн Эрээний дэлгүүрийг онлайн дэлгүүр болгон өөрчлөн онлайн худалдааг идэвхжүүлсэн. <https://gobicashmere.taobao.com/>



# БРЭНДУҮД

**GOBI**  
MONGOLIAN CASHMERE

**GOBI ORGANIC**  
MONGOLIAN CASHMERE

  
**YAMA**  
CASHMERE

  
**GOYO**  
CASHMERE

  
PURE  
MONGOLIAN  
CASHMERE  
**KID  
GOYO**

  
**HERDERS**  
CASHMERE

**GOBI**  
MONGOLIAN CASHMERE

Дэлхийд танигдсан монгол брэнд  
GOBI MONGOLIAN CASHMERE брэнд





**GOBI ORGANIC**  
MONGOLIAN CASHMERE

Ноолуурын байгалийн үндсэн 4 өнгө болох цайвар, цайвар шаргал, хөх саарал, бор өнгүүдийг ашигласан, будаагүй, цайруулаагүй GOBI ORGANIC CASHMERE брэнд



Илүү загварлаг, илүү тансаг зэрэглэлийн YAMA брэнд

Монголоор "Ямаа" буюу тансаг, дулаан ноолуурыг бий болгодог таван хошуу малын нэгээр нэрлэсэн бол Японоор Yama гэх үг нь "Уулын оргил" гэсэн утгатай. Дэлхийн зах зээлд хэдийнээ танигдсан ГОВЬ брэнд тансаг зэрэглэлийн ноолууран бүтээгдэхүүний зах зээлд хүч үзэхийг билэгдэн ийнхүү нэрлэсэн.





Монгол ноолуураар дэлхийг гоёно.  
Goyo Mongolian Cashmere брэнд



Хүүхдийн хөдөлгөөнд саадгүй, хөнгөн, зөөлөн,  
загварлаг KID GOYO хүүхдийн брэнд





БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

“HERDERS” буюу МАЛЧИД төсөл нь Монгол ноолуурын үндэс сурвалж болсон нүүдлийн мал аж ахуй, нутаг бэлчээрийг хадгалах, сэргээхийн төлөө, малчдын гар дээрээс бэлтгэсэн сайн чанартай түүхий эдээр бүтээсэн сул чөлөөтэй, хувиран хөрвөх хэлбэр бүхий эрхэмсэг хэрнээ энгийн оршихуйг илэрхийлсэн загваруудыг танилцуулж байна.



ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН,  
ТЕХНОЛОГИ



ЭРЭГТЭЙ НАРИЙН  
НОЛУУРАН ХОСЛОЛ



ЭМЭГТЭЙ НАРИЙН  
НОЛУУРАН ХОСЛОЛ



ЦУВНЫ КОЛЛЕКЦ



ДОТОРТОЙ ПАЛЫТО


# КОЛЛЕКЦИУД



GOBI ХАВАР/ЗУН 2019



GOBI НАМАР/ӨВӨЛ 2019-20



YAMA ХАВАР/ЗУН 2019



YAMA НАМАР/ӨВӨЛ 2019-20



ОРГАНИК ХАВАР/ЗУН 2019



ОРГАНИК НАМАР/ӨВӨЛ 2018-19



GOYO ХАВАР/ЗУН 2019



GOYO НАМАР/ӨВӨЛ 2019-20

# КОЛЛЕКЦИУД



"IRIS" СИЛКТЭЙ КОЛЛЕКЦ



СААТАЙ "CITRUS" КОЛЛЕКЦ



ДАНИ УЛСЫН БАЛЛЕТЧИДТЭЙ  
ХАМТАРСАН ШИНЭ ШААЛЬ



"BASIC" КОЛЛЕКЦ



"БАЙГАЛЬ" БАРЛАСАН ШААЛЬ



НААДАМ 2019



HOROSCOPE КОЛЛЕКЦ



АКСЕСУАР НАМАР/ӨВӨЛ 2019

# БИДНИЙ ХАРИЛЦАГЧИД






КОМПАНИЙН  
ЗАСАГЛАЛ

# ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Говь ХК-ийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид, удирдлагууд болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, компанийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянахад чиглэсэн бүтэц, зохицуулалтын нийлбэр юм.



Бид 2019 онд компанийн сайн засаглалыг бэхжүүлэн сайжруулах зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийсэн.

1. ТУЗ-ийн дэргэдэх хороод чиг үүргийнхээ хүрээнд дараах ажлыг хийсэн. Үүнд:
  - ТУЗ-ийн өөрийн үнэлгээний асуулгыг шинэчлэн баталсан.
  - ТУЗ-ийн өөрийн үнэлгээг хийж, дүгнэсэн.
  - Компанийн засаглалын өөрийн үнэлгээг хийж Монголын хөрөнгийн бирж болон Компанийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд тайлагнасан.
  - Эрх бүхий албан тушаалтнуудын талаар баримтлах бодлогыг шинэчлэн баталсан.
  - Хараат бус гишүүний шалгуур үзүүлэлтийг баталсан.
  - Эрсдэлийн удирдлагын багийн бүтцийг баталсан.
2. Хувьцаа эзэмшигч нарынхаа эрх ашгийг хангах зорилгоор дараах ажлыг хийсэн. Үүнд:
  - Жилийн үйл ажиллагааны тайланд ТУЗ-ийн үйл ажиллагаа, ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны үр дүнг илүү дэлгэрэнгүй оруулдаг болсон.
  - Хувьцаа эзэмшигчдийн хурал дээр компанийн компанийн үйл ажиллагааны тайлангаас гадна ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг тайлагнадаг болсон.
  - Эрсдэл аудитын хорооны зүгээс компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог үнэлэн дүгнэлт өгдөг болсон.

# ЗАСАГЛАЛЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

Манай компани Монголын хөрөнгийн биржээс батлан гаргасан Хувьцаат компаниудад зориулсан "Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний асуулга" буюу компани өөрийгөө үнэлэх асуулгыг ашиглан Засаглалын өөрийн үнэлгээг 3 дахь жилдээ хийсэн. Энэ жил анх удаа үнэлгээг дотоод аудитын хэлтэс 3 үе шаттайгаар хийсэн ба үүнд: баримт бичгийн шалгалт, хэрэгжилтийг шалгах, үнэлгээ ба тайлагналын үе шат багтсан.

№	Үндсэн зарчмууд	Асуулгын тоо	Бодит үр дүн					Хэрэгжилтийн хувь	
			Бичиг баримт			Хэрэгжилт			
			Авбал зохих оноо	Авсан оноо	Хувь	Үнийн дүн	Тоо ширхэг		Үнийн дүн
А	Хувьцаа эзэмшигчдийн эрх ба хувьцаа эзэмшигчдийн хурал	20	40	34	85.0%	40	33	82.5%	83.8%
Б	Хувьцаа эзэмшигчдийн ижил тэгш байдал	10	20	19	95.0%	20	19	95.0%	95.0%
В	Оролцогч талууд	10	20	17	85.0%	20	15	75.0%	80.0%
Г	Ил тод нээлттэй байдал	20	40	36	90.0%	40	35	87.5%	88.8%
Д	Төлөөлөн удирдах зөвлөл	30	60	52	86.7%	60	51	85.0%	85.9%
Е	Гүйцэтгэх удирдлага	10	20	17	85.0%	20	16	80.0%	82.5%
Нийт		100	200	175	87.7%	200	169	83.3%	86%

ГОВЬ ХК-ИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН  
Нэгдсэн дүнгээс харахад Говь ХК-ийн 2019 оны засаглалын нэгдсэн үнэлгээ нь 86% -тай сайн засаглалтай буюу компанийн удирдлагын үйл ажиллагаа хэвийн гэсэн түвшинд үнэлэгдэж байна.


## ЦААШИД КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХАД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Цаашид сайн засаглалаараа манлайлах зорилтыг тавин үйл ажиллагаанд мөрдлөг болгох баримт бичгийн боловсруулалтыг хийж ажиллах нь зүйтэй гэж дүгнэж байна. Иймд бид цаашид компанийн засаглалаа улам илүү сайжруулахын тулд дараах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна. Үүнд:

- ХЭХ-ийг долоо хоногийн амралтын өдөр зохион байгуулдаг болох. Ингэснээр хувьцаа эзэмшигчдийг өргөнөөр оролцуулж, эрхээ эдлэх боломжийг нэмэгдүүлэх.
- Тайлангийн жил дууссаны дараа ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх, түүнийг тогтмолжуулах
- Хөндлөнгийн аудиторыг сонгон шалгаруулсан байдал, түүний бие даасан, хараат бус байдлыг батлах баримт мэдээллийг ХЭХ-аар хэлэлцэх асуудалд оруулж, мэдээлэл өгдөг болох
- Компани дотоод хяналтын 2-р шатны хяналтыг сайжруулах
- Олон нийтэд тухай бүр хүргэх мэдээллийн агуулга, цар хүрээг улам бүр сайжруулах
- Компанийн цахим хуудсанд байршуулсан мэдээллийн агуулгыг тасралтгүй сайжруулах
- Дотоод мэдээллийн агуулгыг хангах тал дээр тавих хяналтын тогтолцоог илүү сайжруулах



# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД



## НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:

Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо /ширхэг/	Эзэмшлийн хувь
ТАВАН БОГД ТРЕЙД ХХК	391,811,700	50.23%
ХИДЕ ИНТЕР ХХК	265,238,300	34.00%

НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО  
**780,112,500**

НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ТОО  
**17,468**  
/2019.12.31-ний байдлаар/

Тайлангийн хугацаанд Таван Богд Трейд ХХК нь Эф Си Ай ХХК-ийг өөртөө нэгтгэсэнтэй холбогдон, Говь ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орж Таван Богд Трейд ХХК нь Говь ХК-ийн 391,811,700 ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 50.23%-ийг эзэмшдэг болсон.

ХИДЕ ИНТЕР ХХК Хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. (Япон улс)

ТАВАН БОГД ТРЕЙД ХХК нь Таван Богд Группийн толгой компани ба 1997 онд Группийн хэмжээнд бодлого стратегийг нэгдсэн байдлаар тодорхойлох, шинэ бизнесийг нээн хөгжүүлэх, хөрөнгө оруулалт болон салбар компаниуддаа менежментийн дэмжлэг үзүүлэх зорилготойгоор байгуулагдсан.

### ОХИН КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

Герман улс, Шонепелд хот - Говь Кашмер Европ ХХК  
Хятад улс, Эрээн хот - Говь Кашмер (Өвөр Монгол) ХХК  
АНУ, Лос Анжелес - Говь Кашмер Америк ХХК



Таван Богд Групп нь 18 охин компани, 4 хөрөнгө оруулалттай компани, нийт 12,000 гаруй ажиллагсадтайгаар бизнесийн салбар бүртээ манлайлан ажилладаг Монгол улсын манлайлагч групп компани юм.

## ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭЗЭМШСЭН БАЙДАЛ

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ НЭР	ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭЗЭМШСЭН БАЙДАЛ	
	ДАНГААРАА	НЭГДМЭЛ СониРХОЛТОЙ ЭТГЭЭДҮҮД
Д.ХУЛАН	12,247,300 ширхэг (1.57%)	ТАВАН БОГД ТРЕЙД ХХК 50.23%
Ц.БААТАРСАЙХАН	50,000 ширхэг (0.01%)	
НИЙТ		51.80%

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд байгууллага байна. Компани Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа Компанийн тухай хуулийн 62.1-т заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах болон ТУЗ-өөс эсвэл компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэхээр тогтоосон компанийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны гол асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

### ЭЭЛЖИТ ХУРАЛ

Говь ХК нь Хувьцаа эзэмшигчдийнхээ ээлжит хурлыг 2019 оны 4 сарын 18-ны өдрийн 10:00 цагт компанийн Төв дэлгүүрийн дэргэдэх "Мираж" ресторанд зохион байгуулсан. Хуралд 691,528,080 саналын эрхтэй 285 хувьцаа эзэмшигч оролцож, 88.64%-ийн ирцтэйгээр хуралдан дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2018 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн "Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2018 онд төлөвлөгдсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан" гэсэн дүгнэлт өгснийг 99.96%-ийн саналаар батлав.
2. 2017 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2018 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулав.



## КОМПАНИЙН УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

/мян.төг/

ЗАРДЛЫН ТӨРӨЛ	2019.12.31	2018.12.31
ТУЗ-ийн цалин урамшуулал	135,900	184,367
Удирдлагын цалин урамшуулал	1,275,133	1,719,000
Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал	13,825	16,472



# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага бөгөөд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, тэднийг төлөөлж компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах, чиглүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих, чиг үүргийг хэрэгжүүлдэг. ТУЗ-өөс жил бүр компанийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний биелэлтийг сар тутмын тайлангаар хянан, холбогдох үүрэг, чиглүүлгийг өгч ажиллаж байна. Мөн дэргэдээ байнгын үйл ажиллагаатай Эрсдэл аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороодыг байгуулж, компанийн засаглалыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ, Эрсдэл аудитын хорооны удирдлага дор Дотоод аудитын хэлтсийг ажиллуулан компанийн хэмжээнд дотоод хяналтыг хэрэгжүүлж байна.

## ЭРСДЭЛ, АУДИТЫН ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны зорилго нь байгууллагын нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, компанийн дотоод хяналт, журмуудын нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох хууль, дүрэмд нийцсэн байдалд хяналт тавих, эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавин чиглүүлэх, хараат бус аудиторын мэргэжлийн ур чадвар, хараат бус байдлыг үнэлэх, сонгох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар Төлөөлөн удирдах зөвлөлийг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

## БҮРЭЛДЭХҮҮН

Эрсдэл, аудитын хорооны дарга:  
ТУЗ-ийн хараат бус гишүүн  
**Б.Нандин-Эрдэнэ**

Гишүүд:  
ТУЗ-ийн хараат бус гишүүн  
**А.Жаргалмаа**  
ТУЗ-ийн ердийн гишүүн  
**Д.Хулан**

## НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

## БҮРЭЛДЭХҮҮН

Нэр дэвшүүлэх хорооны дарга:  
ТУЗ-ийн хараат бус гишүүн  
**М.Баяр**

Гишүүд:  
ТУЗ-ийн хараат бус гишүүн  
**Д.Гэрэлмаа**  
ТУЗ-ийн ердийн гишүүн  
**Ц.Баатарсайхан**

## ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллыг томъёолох, тогтоох, компанийн хэмжээнд цалин урамшууллын бодлогыг тодорхойлох, эдгээрийн талаар хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

## БҮРЭЛДЭХҮҮН

Цалин, урамшууллын хорооны дарга:  
ТУЗ-ийн хараат бус гишүүн  
**Д.Гэрэлмаа**

Гишүүд:  
ТУЗ-ийн хараат бус гишүүн  
**Такэши Камбэ**  
ТУЗ-ийн ердийн гишүүн  
**Ж.Оюунчимэг**

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН



**Дамбын ГЭРЭЛМАА**

ТУЗ-ийн дарга  
Хараат бус гишүүн  
/Цалин урамшууллын хорооны дарга,  
Нэр дэвшүүлэх хорооны гишүүн/

СЭЗИС, Бизнес удирдлагын тэнхимийн профессор



**Цагаачийн БААТАРСАЙХАН**

ТУЗ-ийн ердийн гишүүн  
/Нэр дэвшүүлэх хорооны гишүүн/

Таван Богд Группийн Ерөнхийлөгч, Говь ХК-ийн Гүйцэтгэх захирал



**Дашдаваагийн ХУЛАН**

ТУЗ-ийн ердийн гишүүн  
/Эрсдэл, аудитын хорооны гишүүн/

Таван Богд Группийн Тэргүүн дэд ерөнхийлөгч



**Такэши КАМБЭ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн  
/Цалин урамшууллын хорооны гишүүн/

Asahi Life Insurance Менежер



**Банзрагчийн НАНДИН-ЭРДЭНЭ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн  
/Эрсдэл, аудитын хорооны дарга/

СЭЗИС, Бизнес удирдлагын тэнхимийн ахлах багш



**Хидэо САВАДА**

H.I.S компанийн Ерөнхийлөгч



**Жавзандолгорын ОЮУНЧИМЭГ**

ТУЗ-ийн ердийн гишүүн  
/Цалин урамшууллын хорооны гишүүн/

Таван Богд Группийн Маркетингийн газрын захирал



**Алтангэрэлийн ЖАРГАЛМАА**

ТУЗ-ийн хараат бус гишүүн  
/Эрсдэл, аудитын хорооны гишүүн/

GAPE, ACCA ахлах багш, хөтөлбөрийн удирдагч



**Мягмарын БАЯР**

ТУЗ-ийн хараат бус гишүүн  
/Нэр дэвшүүлэх хорооны дарга/

ШУТИС-ийн УТС-ийн Хөнгөн Үйлдвэрлэлийн технологи инженерчлэлийн салбарын дэд профессор

## ТУЗ-ИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Агуулга	Баталсан тогтоол	Он сар өдөр
Үйл ажиллагаа өргөжүүлэх, хөрөнгө оруулалт	Гоёо ХХК-ийн нийт гаргасан хувьцааг худалдан авах	2019.05.29
	Гоёо ХХК-г тусгаарлах	2019.06.28
	Компанид Гоёо ноолуур ХХК-ийг нэгтгэх	2019.06.30
	АНУ-ын Калифорни мужийн Лос Анжелес хотод охин компани байгуулахыг зөвшөөрөх	2019.08.30
Компанийн дотоод үйл ажиллагаа	Компанийн 2019 оны бизнес төлөвлөгөө батлах	2019.02.13
	2019 оны сонирхлын зөрчилтэй болон холбоотой талуудтай хийсэн хэлцэл	2019.02.13
	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах	2019.03.07
	Тооллогын комисс томилох	2019.03.07
	Үл хөдлөх хөрөнгө борлуулах эрх олгох	2019.05.20
	Улсын бүртгэлийн гэрчилгээг дахин шинээр гаргуулахыг зөвшөөрөх	2019.06.20
	Компанийн 2019 оны бизнес төлөвлөгөөнд тодотгол хийн шинэчлэн батлах	2019.11.25
	Говь ХК-ийн ТУЗ-ийн нэрэмжит шагналаар шагнах	2019.12.24
Санхүүжилт	2018 оны ногдол ашиг хуваарилах	2019.02.13
	Худалдаа Хөгжлийн банкнаас богино хугацаат санхүүжилт авахыг зөвшөөрөх	2019.04.25
	Монгол Улсын Хөгжлийн банк дахь Гоёо ХХК-ийн зээлийн гэрээг Говь ХК руу шилжүүлэн авахыг зөвшөөрөх	2019.08.30
	Хас банкнаас авсан зээлийн гэрээг сунгуулах	2019.08.30
	Монгол улсын хөгжлийн банкнаас зээл авах	2019.12.04
	Олон улсын хөрөнгө оруулалтын банкнаас зээл авах	2019.12.04
Хүний нөөц	Ажилд томилох тухай ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга	2019.05.20
	ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөх	2019.06.06
	ТУЗ-ийн гишүүнийг түр томилох	2019.06.06
	Гоёо ХХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг томилох	2019.06.28
	ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөх	2019.10.29
	ТУЗ-ийн гишүүнийг түр томилох	2019.11.25
	ТУЗ-ийн гишүүнийг түр томилох	2019.12.10
	ХБНГУ дахь охин компанийн Гүйцэтгэх захирлыг өөрчлөх	2019.09.02

## ТУЗ-ИЙН 2019 ОНЫ ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

№	Огноо	Ээлжит хурал	Ирц	Ээлжит бус хурал	Ирц	Нийт баталсан тогтоолын тоо
1	2019.02.13	*	100%			4
2	2019.03.07			*	100%	2
3	2019.04.08	*	100%			1
4	2019.04.25			*	100%	1
5	2019.05.20			*	88.9%	2
6	2019.05.29	*	100%			1
7	2019.06.06			*	88.9%	2
8	2019.06.20			*	88.9%	1
9	2019.06.28			*	88.9%	2
10	2019.06.30			*	88.9%	1
11	2019.07.22			*	88.9%	1
12	2019.08.30	*	88.9%			4
13	2019.11.25	*	88.9%			2
14	2019.12.04			*	100%	2
<b>Нийт</b>		5		9		26

Тайлбар: Япон улсад байдаг хоёр гишүүд ТУЗ-ийн ээлжит болон ээлжит бус хурлын мэдээллийг цаг тухай бүрд нь и-мэйлээр хүлээн авч, саналаа цахим шуудангаар илгээдэг. Тиймээс хурлын ирцийг оролцсоноор тооцдог.

# ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

“Говь” ХК-ийн Дотоод аудитын хэлтэс нь компанийн бүхий л үйл ажиллагаанд хөндлөнгийн хараат бус хяналтыг тавьж, улирал тутам ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, Аудитын хороонд тайлагнаж, Гүйцэтгэх удирдлагад мэдээлдэг.

Дотоод аудитын хэлтэс нь 2019 онд тодорхойлсон үндсэн чиг үүргийнхээ хүрээнд:

- Баталгаажуулах ажлыг үйл ажиллагааны болон нийцлийн аудитаар ангилан хөндлөн болон босоо хэлбэрээр хийж гүйцэтгэн нийт 82 асуудлыг илрүүлж, үүсэх эрсдэл болон шаардлагатай зөвлөмжүүдийг тодорхойлж өгсөн. Илэрсэн асуудлуудыг шийдвэрлэх, эрсдэлийг бууруулах, үр дүнг сайжруулах талаар өгөгдсөн зөвлөмжүүд нь 71%-ийн гүйцэтгэлтэй байсан. Хөндлөн хэлбэрийн аудитаар процессын сайжруулалтыг хийх, үүссэн асуудлуудыг нэгжийн хүрээнд бус компанийн хэмжээнд бүхэлд нь авч үзэн удирдлагын багийн хамт шаардлагатай сайжруулалтыг хийж хамтран ажилласан.
- Гүйцэтгэх удирдлагын хүсэлтээр үйл ажиллагааг сайжруулах зорилгоор 2 удаагийн зөвлөх үйлчилгээг үзүүлж, хамтарч ажилласан.
- Компанийн засаглал, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэхэд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу үнэлж, компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, тасралтгүй сайжруулах талаар зөвлөмж, дэмжлэгийг өгч ажилласан.

Дотоод аудитын хэлтэс нь Дотоод аудиторчуудын институт (IIA)-ээс гаргадаг Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ (IPPF)-г баримтлан, компанийн засаглал, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоог үнэлж, үнэ цэнийг нэмэгдүүлэх, сайжруулахад бие даасан, бодитой баталгаажуулах, зөвлөх үйлчилгээг үзүүлж, аудитын үйл ажиллагаанд чанарын баталгаажуулалтыг дотооддоо хийж, удирдлагыг бодит мэдээллээр ханган, хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг болж ажиллана.

# ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Манай компани нь дотоод хяналтдаа “Хамгаалалтын 3 шугам” загварын дагуу зохион байгуулалтыг хийж, үйл ажиллагаагаа сайжруулан ажиллаж байна. Энэ загвар нь шат шатны удирдлагууд өдөр тутмын төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах, хянах, зохицуулах үндсэн чиг үүргүүдээ хэрэгжүүлэн ажиллахад ач холбогдолтой байдаг.



### Хамгаалалтын I шугам:

Компанийн үндсэн үйл ажиллагааг явуулж буй нэгжүүд Гүйцэтгэх удирдлагаас өгсөн чиг үүргийн дагуу өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлж, тайлагнадаг.

### Хамгаалалтын II шугам:

Компанийн үндсэн үйл ажиллагааг дэмжиж ажилладаг нэгжүүд Гүйцэтгэх удирдлагаас өгсөн чиг үүргийн дагуу өдөр тутмын хяналтыг давхар хэрэгжүүлж, тайлагнадаг.

### Хамгаалалтын III шугам:

Гүйцэтгэх удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтын тогтолцоо нь хэрэгжиж байгаа эсэх, оновчтой байгаа эсэх дээр баталгаажуулалтыг хийж, үндсэн чиг үүргийн хувьд Эрсдэл, аудитын хороонд, захиргааны хувьд Гүйцэтгэх удирдлагад тайлагнадаг.

Ийнхүү чиг үүргийнхээ дагуу давхар тайлагнаснаар Дотоод аудитын хараат бус байдал хангагдаж, бодитой, зохисгүй нөлөөллөөс ангид ажиллаж байна

## ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ТАЙЛАН

### ЭРСДЭЛ, АУДИТЫН ХОРОО

#### 2019 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Эрсдэл аудитын хороо нь 2019 онд 3 удаа ээлжит хурал зохион байгуулж, 17 асуудлыг хэлэлцэн, 3 тогтоол гаргав. Мөн хорооны чиг үүргийнхээ хүрээнд 7 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч, хяналт тавьж ажиллав.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах чиг үүргийн хүрээнд санхүүгийн тайлан, НББ-ийн талаар хараат бус аудиторын дүгнэлт зөвлөмжтэй танилцаж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан бөгөөд эрсдэлийн удирдлагын баг болон дотоод аудитын хэлтсийн ажлын гүйцэтгэл, хагас жилийн ажлын тайлантай цаг тухай бүрд танилцаж чиглүүлэн ажиллав. Мөн эрсдэлийн удирдлагын багийн бүтцийг шинэчлэн баталж дотоод аудитын хэлтсийн даргын сонгон шалгаруулалтыг явуулж, дотоод аудитын хэлтсийн 2020 оны үйл ажиллагаа болон цалингийн төсвийг батлав.

### НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

#### 2019 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Нэр дэвшүүлэх хороо нь 2019 онд 3 удаа ээлжит хурал зохион байгуулж, 9 асуудлыг хэлэлцэн, 3 тогтоол гаргав. Хорооны чиг үүргийн хүрээнд удирдлагуудад 4 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч ажиллав.

Энэ онд “Эрх бүхий албан тушаалтнуудын талаар баримтлах бодлого”, ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн шалгуур үзүүлэлт, ТУЗ-ийн өөрийн үнэлгээний асуулга зэргийг баталлаа. Түүнчлэн удирдлагын багийн хагас жилийн тайлан, тус тайланд гүйцэтгэх захирлаас өгсөн дүгнэлттэй танилцав. 2019 оны ТУЗ-ийн өөрийн үнэлгээг хийж, үр дүнд үндэслэн ТУЗ болон хороодын үйл ажиллагааг сайжруулах, цаашид гүйцэтгэх ажлуудыг хэлэлцсэн. Компанийн засаглалын өөрийн үнэлгээг дотоод аудитын хэлтэстэй хамтран гүйцэтгэж Монголын хөрөнгийн бирж болон компанийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд тайлагнан ажиллалаа.

### ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХОРОО

#### 2019 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Цалин урамшууллын хороо нь 2019 онд 1 удаа ээлжит хурал зохион байгуулж, 3 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. Мөн хорооны чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч чиглүүлэн ажиллав.

Энэ онд тус хороо нь компанийн хэмжээнд цалин урамшуулал, нийгмийн халамжийн хүрээнд хийгдсэн ажлын тайлан, компанийн соёлын болон сэтгэл ханамжийн судалгааны ажлын үр дүнтэй танилцан санал зөвлөмжийг өгч ажиллалаа.

Мөн хорооны чиг үүргийнхээ дагуу өнгөрсөн оны цалин урамшууллын гүйцэтгэлд хяналт тавьж, ирэх жилийн цалин урамшууллын төсвийг баталлаа.

## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Засаглалын хувьд “Хамгаалалтын 3 шугам” загварын дагуу эрсдэлийн удирдлагын зохион байгуулалтыг хийн, ажиллаж байна. Эрсдэлийн удирдлагын 2-р шугамын хамгаалалтыг Эрсдэл аудитын хорооноос томилогдсон Эрсдэлийн удирдлагын баг хариуцан ажилладаг. Эрсдэлийн удирдлагын багийг компанийн удирдах албан тушаалтнууд бүрдүүлж байгаа бөгөөд Тэргүүн дэд захирал ахлан ажиллаж байна.




Эрсдэлийг удирдах процесс дээр шинжилгээ хийж, сайжруулах зорилгоор 2019 оны 4-р улиралд СЭЗИС-ийн Санхүүгийн удирдлагын тэнхимээс зөвлөгөө авч, процесс, бодлого, журмын хамтран ажилласан.

### 2020 ОНД ХИЙГДЭХ АЖЛЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ:

2020 онд үндсэн 3 чиглэлээр ажлууд төлөвлөгдөж байна. Үүнд:

1. Эрсдэлийн удирдлагын баримт бичгийн сайжруулалт: Бодлогын баримт бичиг, журмыг шинэчлэн сайжруулах, гарын авлагыг шинээр боловсруулах, нэгжийн удирдлагын ажлын байрны тодорхойлолтод эрсдэлийг удирдах чиг үүргийг тусгаж өгөх.
2. Эрсдэлийн соёлын сайжруулалт: Баримт бичгийн шинэчлэлтийг ажилтнуудад таниулах, эрсдэлд суурилсан сэтгэлгээ, хандлагыг бий болгох.
3. Эрсдэлийг удирдлагын хэрэгжүүлэлтийг сайжруулах: Эрсдэлийн удирдлагын процессыг эргүүлэх, учирч болох томоохон эрсдэлүүдийг тодорхойлох, удирдах, тухайн эрсдэлүүд дээр индикаторуудыг тодорхойлон, мониторинг хийж, тогтмол хянах.

# КОМПАНИЙН БҮТЭЦ



## КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ГАРСАН ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮД

1. Говь ХК болон Гоёо ХХК нэгдсэнтэй холбоотойгоор Үйлдвэр хариуцсан Дэд захирал,
2. 2019 оны 3-р улирлаас эхлэн Цахим борлуулалтын сувгийг эрчимтэй хөгжүүлж эхэлсэнтэй холбоотой Онлайн хариуцсан Дэд захирал шинэ албан тушаалуудыг тус тус үүсгэсэн.

## КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД



**ЦАГААЧИЙН  
БААТАРСАЙХАН**

Гүйцэтгэх захирал



**НЯМЖАВЫН  
СҮРЭНРАГЧАА**

Тэргүүн дэд захирал



**ЦОГТГЭРЭЛИЙН  
ОРГИЛБОЛД**

Үйлдвэр хариуцсан  
дэд захирал



**БАТЧУЛУУНЫ  
АРИУНАА**

Онлайн хариуцсан  
дэд захирал



**ЧУЛУУНБАТЫН  
СОЛОНГО**

Хүний нөөц,  
захиргаа хариуцсан  
захирал



**ГАНБОЛДЫН  
СЭЛЭНГЭ**

Санхүү хариуцсан  
захирал



**БАТСУУРИЙН  
БОЛОРМАА**

Дизайн хөгжүүлэлт  
хариуцсан захирал



**ЧҮЛТЭМИЙН  
ЛХАГВАЦЭРЭН**

Маркетинг хариуцсан  
захирал



**БАТМӨНХИЙН  
АЛТАНБУЯН**

Дотоод худалдаа  
хариуцсан захирал



**ЦЭГМЭДИЙН  
ЗОЛБОО**

Гадаад худалдаа  
хариуцсан захирал



**ЦОГТБАЯРЫН  
ЦАСЧИХЭР**

Хуулийн хэлтсийн  
дарга




**САРУУЛЫН  
БОЛОРМАА**

ТУЗ-ийн нарийн  
бичгийн дарга



# ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА КОМПАНИЙН ХУВЬЦАА

Говь ХК-ийн зах зээлийн үнэлгээ 2019 оны эцсийн байдлаар 210,630,375,000 төгрөг байна. Жилийн арилжааны мэдээллийг графикаар үзүүлэв.



## 52 ДОЛОО ХОНОГИЙН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ ХАНШ

ҮЗҮҮЛЭЛТ	2019 оны 12/31	2018 он	Өсөлт, бууралт
			2019/2018
<b>ХУВЬЦААНЫ ҮНЭ /төг/</b>			
Хаалтын үнэ	270	333.89	19.1% ↓
Хамгийн их үнэ	354.11	369.77	4.2% ↓
Хамгийн бага үнэ	251.98	205.20	22.8% ↑
Дундаж үнэ	291.60	266.80	9.3% ↑
<b>АРИЛЖААЛАГДСАН ТОО /шир/</b>			
Хамгийн их /өдөрт/	261,527	428,390	39% ↓
Хамгийн бага /өдөрт/	1,068	18	5,833% ↑
Дундаж /өдөрт/	31,146	7,862	296.2% ↑
Нийт	7,848,937	1,886,927	316% ↑
<b>АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН /төг/</b>			
Хамгийн их /өдөрт/	87,630,808	328,449,260	73.3% ↓
Хамгийн бага /өдөрт/	284,711	429,000	33.6% ↓
Дундаж /өдөрт/	9,398,943	17,980,871	47.7% ↓
Нийт	2,368,533,634	4,315,409,014	45.1% ↓
<b>ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ /төг/</b>	<b>210,630,375,000</b>	<b>260,471,762,625</b>	<b>19.1% ↓</b>

## НОГДОЛ АШИГ

Манай компани нь дотоодын зах зээлд байр сууриа хадгалах, улмаар зах зээлд эзлэх хувиа өсгөх, гадаад зах зээлээ тэлэхийн тулд техник, технологио шинэчлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр чармайн ажиллахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгө оруулалтын өгөөжийг тасралтгүй өсгөж, ногдол ашиг тогтмол тараах бодлогыг баримталдаг.

Ногдол ашиг зарласан он	Хувьцааны тоо /шир/	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг /төг/	Нийт зарласан ногдол ашгийн дүн /төг/	Ногдол ашиг тараалт
1996	7,801,125	61.00	475,868,625	Говь ХК нь 2007 онд хувьчлагдсан бөгөөд түүнээс өмнөх жилүүдэд зарласан ногдол ашгийг компани дээрээ тарааж байна.
1997	7,801,125	153.80	1,199,813,025	
1998	7,801,125	150.00	1,170,168,750	
1999	7,801,125	166.00	1,294,986,750	
2000	7,801,125	100.00	780,112,500	
2001	7,801,125	20.16	157,270,680	
2005	7,801,125	60.00	468,067,500	
2006	7,801,125	60.00	468,067,500	
2010	7,801,125	100.00	780,112,500	
2011	7,801,125	100.00	780,112,500	
2012	7,801,125	125.00	975,140,625	
2013	7,801,125	130.00	1,014,146,250	
2014	7,801,125	140.00	1,092,157,500	
2015	7,801,125	140.00	1,092,157,500	
2016	7,801,125	200.00	1,560,225,000	
2017	7,801,125	220.00	1,716,247,500	
2018	780,112,500	6.80	5,304,765,000	2019 оны 4 сарын 25-ны өдрөөс эхлэн компани дээрээ тарааж, хувьцаа эзэмшигчдэд хүссэн үед нь бэлэн мөнгөөр эсвэл харилцах дансанд нь шилжүүлэх замаар чирэгдэл багатай арга хэлбэрээр саадгүй олгох бөгөөд 2019 оны эцэст ногдол ашгийн үлдэгдэл тооцоог гарган Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны дансанд нь шилжүүлэх болно.
2019	780,112,500	-	-	2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 04 тоот тогтоолын дагуу 2019 оны ногдол ашиг хуваарилахгүй болно.





ТОГТВОРТОЙ  
ХӨГЖИЛ

# 2019 ОНД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН ОНЦЛОХ АЖЛУУД

Говь ХК нь ноос ноолуурын салбарын тэргүүлэгч компанийн хувьд салбарын болоод улс орныхоо эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулахыг эрхэмлэн ажилладаг. Бид хүрээлэн буй байгаль орчиндоо сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг ямагт тооцоолж, түүнээс сэргийлэн, нийгмийн хариуцлагаа ухамсарлан, малчид болон орон нутгийн байгууллагуудтай хамтран бэлчээрийн зөв зохистой ашиглалтыг дэмжин ажиллаж, байгальд ээлтэй техник технологийг эрэлхийлэн үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, нөөцийн зүй зохистой хэрэглээг хэвшүүлэхийг зорьдог.

Энэхүү зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны үе шат бүртээ тогтвортой хөгжлийн түлхүүр болсон үзүүлэлтүүдийг орхигдуулалгүй уялдуулан, хэвшүүлж чадсанаар эрүүл эргэх холбоог цогцлоож чадах бөгөөд манай компанийн бизнесийн үйл ажиллагаа урт хугацаандаа улам бүр батжин, улс орныхоо ирээдүй, хойч үед өвлүүлэх баялаг бүтээгч болох болно.



Бид тогтвортой хөгжлийн хүрээнд:

## МАЛЧНЫ ХОТНООС, ДЭЛХИЙН БРЭНД ТӨСӨЛ

### Төслийн цар хүрээ

Говь ХК-ийн болон Европын Сэргээн Босголтын Хөгжлийн банкны санхүүжилтаар Sustainable Fibre Alliance хэрэгжүүлж буй төсөл нь газарзүйн хувьд тусдаа өөр байрлалтай хоёр сумын хоршоодтой хамтарч ажиллахаар тусгасан байна.

- “Дэлгэрэхийн улаан ямаа” хоршоо. Дорноговь аймгийн Дэлгэрэх сум, ямааны цөм сүрэг нь “Улаан ямаа”
- Баянхонгор аймгийн Шинэжинст сумын “Залаа жинст торгон сүрэг хоршоо”

Төслийн гол зорилго нь бэлчээрийн менежмент, малын эрүүл мэнд, малчдын дадлага туршлагыг сайжруулахын тулд 3 жилийн туршилтын загвар хоршоог бий болгоход оршино. Энэхүү загвар хоршоо нь амжилттай бий болсноор цаашид Монгол улсын хэмжээнд хэрэгжүүлэх, ноолуур бэлтгэлийн сүлжээг хөгжүүлэх боломж бүрдэнэ.

### Төслийн зорилтууд

- Бэлчээрийн доройтлоос урьдчилан сэргийлэхийн тулд зохистой менежментийн дадлыг нэвтрүүлэх
- Хоршоод буюу малчдыг малын эрүүл мэнд, мал эмнэлгийн практикийг хэрэгжүүлдэг хариуцлагатай ноолуур үйлдвэрлэгч болгох
- Хоршоонд суурилан үржлийн болон сүргийн чанарыг сайжруулах зохистой дадлыг нэвтрүүлэх
- Ноолуурыг ангилан бэлтгэх мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх сургалт зохион байгуулах
- Залуу малчдын чадавхыг нэмэгдүүлж тогтвортой бэлтгэн нийлүүлэгч болгох

### Хүлээгдэж буй үр дүн

- Ноолуурын чанар сайжрах
- Ноолуур бэлтгэн нийлүүлэлтийн чанарын тогтвортой байдал нэмэгдэх,
- Цаг уурын өөрчлөлтөд тогтвортой ажиллах
- Улирлын чанартай бэлчээр ашиглалтын уламжлалыг сэргээж, байгаль орчны эерэг нөлөөлөл бий болгох
- Түүхий эдийн чанар сайжирсантай холбоотой малчдын орлого нэмэгдэх

**GOBI**  
MONGOLIAN CASHMERE

  
**European Bank**  
for Reconstruction and Development

  
**SUSTAINABLE FIBRE ALLIANCE**  
Creating a sustainable cashmere supply chain

## ISO СТАНДАРТ

“Говь” ХК нь бизнесийнхээ хөгжлийн чиг хандлагыг ногооруулж, тогтвортой хөгжих үзэл санаанд тулгуурлан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компани болох зорилгоор 2019 оны 04-р сарын 05-ны өдрөөс байгууллагын хэмжээнд Нэгдмэл Удирдлагын Тогтолцооны дараах 3 стандартыг

- Олон улсын чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2015,
- Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO45001:2018,
- Байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO14001:2015 стандартыг тус тус нэвтрүүлж эхэлсэн.



Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо болон Байгаль орчны удирдлагын тогтолцооны стандартын төслийн эхлүүлэлт, төлөвлөлт, хэрэгжүүлэлт, мониторингийн үе шатны ажлууд хийгдсэн бөгөөд удирдлагын дүн шинжилгээ болон төслийг хаах (баталгаажуулалт) үе шатанд бэлтгэж байна.

Олон улсын чанарын удирдлагын тогтолцооны төслийн хувьд 2020 оны намар баталгаажуулалтын аудитад орох төлөвлөгөөтэй байна.

## БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО

- Бид бизнесийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд учирч болзошгүй байгаль орчны сөрөг нөлөөллийг ухамсарлан тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг дэмжиж, хүрээлэн буй орчиндоо хариуцлагатай хандахыг эрхэмлэнэ.
- Бид үйл ажиллагааныхаа алхам бүрд Монгол улсын Байгаль орчны тухай хууль тогтоомж тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, стандартуудыг мөрдөн “НОГООН ЗАРЧИМ”-ыг бий болгоно. Орчин үеийн дэвшилтэд технологийг ашиглан, байгаль орчинд ээлтэй “НОГООН ХУДАЛДАН АВАЛТ”-ыг дэмжиж, үйл ажиллагааг ухаалгаар удирдах замаар байгаль орчинд хамгийн бага ул мөр үлдээхийг эрхэмлэн ажиллана. Уламжлалт ёс заншлаа хүндэтгэн, ажилтнуудынхаа байгаль орчинд хандах хандлага, мэдлэгийг сайжруулан “НОГООН СОЁЛ”-ыг төлөвшүүлнэ. Түүхий эдийн амьдралын мөчлөгийн хугацаанд байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, байгалийн нөөц баялгийг хамгийн бага төвшинд ашиглан Байгаль орчны удирдлагын “НОГООН ТОГТОЛЦОО”-г бий болгон тасралтгүй сайжруулан ажиллана.

## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яамаар батлуулан, хэрэгжилтийг нийслэлийн байгаль орчны газарт тайлагнан ажиллав.



Нийт хог хаягдлын 31%-ийг дахин боловсруулалтад өгсөн. Аюултай хог хаягдал буюу батарейны 560 ширхэг хаягдлыг цуглуулан Монголын Хог хаягдлын Үндэсний холбоо ТББ хүлээлгэн өгсөн. Энэ нь бид 4,480,000 литр цэвэр ус, 560 м<sup>3</sup> хөрсийг бохирдохоос сэргийлж чадсан.



### “ЭХ ДЭЛХИЙГЭЭ ХАМГААЛАХ ЭНГИЙН АЛХАМ”

Говь брэнд бүтээгдэхүүн үйлчилгээндээ байгальд ээлтэй даавуун эко торыг сонгон ашиглаж эхлээд байна. Тус даавуун тор (Nonwoven bag)-ны гол орц нь PP (polypropylene) юм.

Nonwoven материалын давуу тал нь байгаль орчинд ээлтэй, бат бөх, амьсгалдаг, усны хамгаалалттай, уян хатан, хоргүй юм. Тус тор нь ил задгай нөхцөлд өөрөөр нь байлгахад 90 хоногийн дотор уусаж алга болдог бол өрөөний температурт 8 жил болж уусч алга болдог онцлогтой. Мөн шатаахад ямар ч хорт бодис ялгарахгүй, амтгүй, үлдэгдэл тунадас үлдэхгүй бөгөөд байгаль орчинд ямар ч хор нөлөөгүй юм.

# ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-2019 ОНД



Говь ХК-ийн дотоодын зах зээлд борлуулагдсан ноолууран пальто болон пиджак бүрээс хуримтлагдсан 1,000 төгрөгийг нийгмийн сайн сайхны төлөөх үйлсэд зориулан ажилласаар байна.



Говь ХК нь Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 100 ширхэг мод тарьж, Говь ХК-ийн төгөлтэй болсон. Мөн нийт ажилтнууд өөрсдийн санхүүжилтээрээ 400 ширхэг модыг СХД-ын агаарын бохирдол ихтэй газарт тус тус тарьсан.



Говь ХК нь ирээдүйн боловсон хүчнийг бэлтгэх, хөгжүүлэх зорилгоор Монгол-Солонгосын политехник коллеж болон Үйлдвэр урлалын политехник коллежтэй хамтран тусгай дунд боловсрол эзэмшиж байгаа оюутнуудыг дэмжин ажилладаг бөгөөд урт болон богино хугацааны дадлага хийлгэн дадлагын ажлаа сайн хийж гүйцэтгэсэн оюутнуудыг урилгаар ажиллуулдаг билээ. 2019 онд нийт 29 оюутанд Говь ХК-д ажиллах урилга өгч ажлын байраар хангав.



Санхүү Эдийн Засгийн Их Сургуультай хамтран "ӨНГӨ НЭМБЕ" өсвөр үеийнхэнд хорт зуршлын сөрөг нөлөө болон түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дэмжин оролцсон.

# ЧАНАРЫН УДИРДЛАГА

Говь ХК нь түүхий эдээ малчдын гараас хүлээн авахаас эхлэн бэлэн бүтээгдэхүүн хүртэлх бүхий л шат дамжлагад 230 үзүүлэлтээр чанарын шалгалтыг хийж, технологийн горимыг чанд мөрдөн, бүтээгдэхүүнээ олон улсын ISO 9001:2008/MNS ISO 9001:2010, ISO/IEC 17025:2005/ MNS ISO/IEC 17025:2007 стандартын шаардлагын дагуу үйлдвэрлэж, баталгаажуулан дотоод, гадаадын хэрэглэгчдэд хүргэдэг.

Бид хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэхээр үйлдвэрлэлийн шат дамжлага бүрээр чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэн, чанарын 102 MNS стандарт, компанийн нийт 104 журам, стандарт, технологийн горим, ажлын зааварчилгааг мөрдөж, чанарын хяналт шалгалтыг 100% хийж, чанарын удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулан ажиллаж байна.


2020 онд бид Олон улсын чанарын ISO 9001:2015 стандарт, Байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO 14001:2015 стандарт болон Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын ISO 45001:2018 стандартуудыг хэрэгжүүлэн баталгаажуулалт авахаар ажиллаж байна.



1999 онд- ISO/IEC 17025:2005 (MNS ISO/IEC 17025:2007) стандартын шаардлага хангасан "Хэмжих хэрэгслийн лаборатори"



"Монголын Хаан Ширхэгт" –ийг гэрчилэх тэмдэгтийг /санмасан ноолуур, сүлжмэл цамц/ цогцолбор үйлдвэр авсан.



ГОВЬ ХК  
БОЛОН ТҮҮНИЙ ОХИН  
КОМПАНИУДЫН

НЭГТГЭСЭН  
САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН

2019 ОНЫ 12 САРЫН 31

ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД  
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН  
2019 ОНЫ 12 САРЫН 31

## АГУУЛГА

## ХУУДАС

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	1
Нэгтгэсэн иж бүрэн орлогын тайлан	2
Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	3
Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	4

ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД  
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2019 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	2019	2018
<b>Хөрөнгө</b>		
<i>Эргэлтийн хөрөнгө</i>		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	10,641,744	4,940,940
Дансны ба бусад авлага	12,976,180	12,183,569
Урьдчилгаа төлбөр	4,215,397	4,690,681
Бараа материал	178,135,943	142,538,944
Орлогын албан татварын авлага	266,632	
Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө	565,290	268,017
	<b>206,801,186</b>	<b>164,622,151</b>
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>		
Үндсэн хөрөнгө	134,043,015	82,380,060
Ашиглах эрхтэй хөрөнгө	2,371,039	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	2,710,343	1,250,554
Бусад эргэлтийн бус хөрөнгүүд	574,327	355,697
	<b>139,698,724</b>	<b>83,986,311</b>
	<b>346,499,910</b>	<b>248,608,462</b>
<b>Нийт хөрөнгө</b>		
<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч</b>		
<i>Богино хугацаат өр төлбөр</i>		
Дансны ба бусад өглөг	37,803,959	4,741,052
Орлогын албан татварын өглөг	-	1,755,234
Буцаах эрхтэй барааны өр төлбөр	913,198	466,329
Түрээсийн өр төлбөр	686,742	-
Гэрээний өр төлбөр	2,153,354	1,037,239
Богино хугацаат банкны зээл	189,267,962	113,722,628
	<b>230,825,215</b>	<b>121,722,482</b>
<i>Урт хугацаат өр төлбөр</i>		
Урт хугацаат түрээсийн өр төлбөр	1,865,656	-
Урт хугацаат өглөг	2,085,657	3,231,805
Урт хугацаат банкны зээл	32,560,000	6,000,000
	<b>36,511,313</b>	<b>9,231,805</b>
	<b>267,336,528</b>	<b>130,954,287</b>
<b>Нийт өр төлбөр</b>		
<b>Эзэмшигчдийн өмч</b>		
Хувьцаат капитал	780,113	780,113
Дахин үнэлгээний нэмэгдэл	15,647,697	15,647,697
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(278,529)	(135,203)
Хуримтлагдсан ашиг	63,014,101	101,361,568
	<b>79,163,382</b>	<b>117,654,175</b>
	<b>346,499,910</b>	<b>248,608,462</b>
<b>Нийт өр төлбөр ба Эзэмшигчдийн өмч</b>		



ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД  
НЭГТГЭСЭН ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2019 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	2019	2018
Борлуулалтын орлого	209,748,268	173,439,375
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(141,951,917)	(102,147,527)
<b>Нийт ашиг</b>	<b>67,796,351</b>	<b>71,291,848</b>
Санхүүгийн ба бусад орлого	711,312	542,045
Бусад (гарз) ба олз	(3,445,430)	(6,561,605)
Хүүгийн зардал	(21,811,123)	(10,521,942)
Борлуулалт ба маркетингийн зардал	(27,941,691)	(21,244,284)
Ерөнхий ба удирдлагын зардал	(10,243,248)	(10,256,107)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт	(978,735)	(1,523)
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>4,087,436</b>	<b>23,248,432</b>
Орлогын татварын зардал	(1,630,963)	(5,484,268)
<b>Тайлант жилийн цэвэр ашиг</b>	<b>2,456,473</b>	<b>17,764,164</b>
<b>Дараа үеүдэд ашиг, алдагдал руу ангилагдах бусад иж бүрэн орлого:</b>		
Гадаад дахь охин компаниас үүссэн валют хөрвүүлэлтийн зөрүү	(143,326)	(106,929)
<b>Бусад иж бүрэн алдагдал</b>	<b>(143,326)</b>	<b>(106,929)</b>
<b>Нийт иж бүрэн орлого</b>	<b>2,313,147</b>	<b>17,657,235</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох ашиг – суурь төгрөг</b>	<b>2.97</b>	<b>22.63</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох ашиг – хорогдуулсан төгрөг</b>	<b>2.97</b>	<b>22.63</b>

ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД  
НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2019 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт
<b>2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>780,113</b>	<b>15,647,697</b>	<b>(28,274)</b>	<b>85,313,652</b>	<b>101,713,188</b>
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	-	17,764,164	17,764,164
Бусад иж бүрэн алдагдал	-	-	(106,929)	-	(106,929)
Тайлант жилийн нийт иж бүрэн орлого	-	-	(106,929)	17,764,164	17,657,235
Зарласан ногдол ашиг	-	-	-	(1,716,248)	(1,716,248)
<b>2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>780,113</b>	<b>15,647,697</b>	<b>(135,203)</b>	<b>101,361,568</b>	<b>117,654,175</b>
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	-	2,456,473	2,456,473
Бусад иж бүрэн алдагдал	-	-	(143,326)	-	(143,326)
Тайлант жилийн нийт иж бүрэн орлого	-	-	(143,326)	2,456,473	2,313,147
Үйл ажиллагааны нэгдэл	-	-	-	(35,499,175)	(35,499,175)
Зарласан ногдол ашиг	-	-	-	(5,304,765)	(5,304,765)
<b>2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>780,113</b>	<b>15,647,697</b>	<b>(278,529)</b>	<b>63,014,101</b>	<b>79,163,382</b>

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД  
НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2019 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	<b>2019</b>	<b>2018</b>
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	41,799,388	(14,574,308)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(34,127,136)	(27,855,178)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(2,031,447)	40,188,544
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	5,640,805	(2,240,942)
Мөнгөний үлдэгдэл дэх ханшийн зөрүүгийн нөлөөлөл	59,999	(1,880)
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b><u>4,940,940</u></b>	<b><u>7,183,762</u></b>
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b><u>10,641,744</u></b>	<b><u>4,940,940</u></b>

# МОНГОЛ ДАХЬ ДЭЛГҮҮРҮҮДИЙН БАЙРШИЛ

## ҮЙЛДВЭРИЙН ДЭРГЭДЭХ ТӨВ ДЭЛГҮҮР

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, Үйлдвэрийн гудамж  
Утас: 7004 8888

## ГАЛЛЕРИА УЛААНБААТАР САЛБАР

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Засгийн газрын ордны зүүн талд  
Утас: 7004 8888

## OUTLET ДЭЛГҮҮР

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, Үйлдвэрийн гудамж  
Утас: 7004 8888

## СМАРТ САЛБАР

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Өргөө кино театрын урд талд, Смарт худалдааны төвийн 1 давхарт; Утас: 7004 8888

## ДАРХАН ХОТ САЛБАР

Дархан хот, Шинэ Дархан Олон Улсын Худалдааны Төв  
Утас: 95056656, 99376775

## ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДАЛ САЛБАР

Чингис хаан олон улсын нисэх буудал дахь зорчин явагчдын танхимд

# ГАДААД ДАХЬ ДЭЛГҮҮРҮҮДИЙН БАЙРШИЛ

## САЛБАР ДЭЛГҮҮРҮҮД

### BERLIN, GERMANY

GOBI MONGOLIAN CASHMERE  
Knesebeckstr.30, Berlin, Germany  
www.gobicashmere.com  
+49 (0)30 224 66510

### BERLIN, GERMANY

Mall Of Berlin, Leipziger platz 12, Berlin, Germany

### HAMBURG, GERMANY

GOBI MONGOLIAN CASHMERE  
Galleria Hamburg, Große Bleichen 21, Hamburg, Germany  
+49(0)30 244 665 10

### ERLIAN, INNER MONGOLIA, CHINA

MinMao Department store, 2nd floor, Erlian  
+86-18747458506

## ФРАНЧАЙЗ ДЭЛГҮҮРҮҮД

### ASIA

#### ANKARA, TURKEY

GOBI CASHMERE  
Armada 1, 1.kat No:136, Eskişehir Yolu No:6 06560  
Söğütözü  
Tel: +90 (312) 219 16 01-02,  
Fax: +90 (312) 219 16 03  
Email: info@gobi.com.tr,  
Web: www.gobi.com.tr

#### ISTANBUL, TURKEY

MONGOLIAN CASHMERE GOBI  
HARBİYE MAHALLESİ ABDİ İPEKÇİ CADDESİ BRONZ  
SOKAK NO: 7D POSTA KODU: 34367 ŞİŞLİ -İSTANBUL,  
TÜRKİYE

#### ALMATY, KAZAKHSTAN

ГОБИ  
Проспект Абылай Хана 62, Алма-Ата  
+772 731 17035

#### ASTANA, KAZAKHSTAN

ЛЮКС КАШЕМИР  
Z05P5TD Астана, проспект Мангелик ЕЛ 35, в/п 24,  
магазин Zharuma  
+771 727 53952

#### ERLIAN, INNER MONGOLIA, CHINA

No.010112 Quanjin Road Xilin street, Erlian haote, Inner  
Mongolia, China

#### HAILAAR, CHINA

No.3-2, Dongda street, Hailar dictrict, Hulunbur city,  
Inner Mongolia, China

#### HUHHOT, CHINA

GOBI CASHMERE  
Zhongshan West Road, Hohhot

#### HONG KONG, CHINA

GOBI MONGOLIAN CASHMERE  
RM 18-20, 17/F, Horizon Plaza, 2Lee Wing street, Ap Lei  
Chau, Hong Kong, China  
+852 2730 3911

#### HONG KONG, CHINA

GOBI MONGOLIAN CASHMERE  
Man Yee building, 68 Des Voeux road Central, 2nd floor,  
Shop 214, Central, Hong Kong

#### ULANHOT, INNER MONGOLIA, CHINA

GOBI MONGOLIAN CASHMERE  
New century square, 42-11, Wulanhaote city, Inner  
Mongolia, China

#### FUZHOU, CHINA

GOBI MONGOLIAN CASHMERE  
2nd floor, Baolong Xinhua, Taijiang District Industrial  
Road, Fujian Province

#### SHANGHAI, CHINA

GOBI MONGOLIAN CASHMERE  
Shanghai New World Daiwan No.228 Nanjing east road,  
Huangpu district.  
+86 18800337221

#### MANZHOU, CHINA

GOBI MONGOLIAN CASHMERE  
China and Russian Duty Free trade zone B Hall, M203,  
Manzhouli, China

#### SEOUL, KOREA

GOBI KOREA  
Room 201, Jinsung B/D, Abujungro 4 gil 13-9,  
Gangnam-gu, Seoul, Korea  
+02 518 0525

#### SEOUL, KOREA

GOBI KOREA  
843, Seolleung-ro, Gangnam-gu, Seoul, Korea  
+02 518 0525

#### DEAGU, KOREA

GOBI KOREA  
DEBEC PLAZA  
333, Myeongdeok-ro, Jung-gu, Daegu, Republic of Korea

#### TOKYO, JAPAN

Haneda Airport, 1 Terminal, Market place 4F

## EUROPE

### DÜSSELDORF, GERMANY

GOBI  
Königsallee 60, 40212 Düsseldorf, Germany

### NAPLES, ITALY

GOBI CASHMERE  
Via nazionale Delle Puglie, 88, San Vitaliano, (NA)

### NAPLES, ITALY

GOBI CASHMERE  
Via Calabritto, 21 80121 Napoli

### PRAGUE, CZECH

GOBI KAŠMÍR  
V Jame 3, 110 00 Praha 1, Czech  
+42 (0) 702 065 696  
www.kasmir.cz

**PRAGUE, CZECH** 
ГОБИ КАՏՄԻՐ 
MAISELOVA 5, 110 00, Praha 1, Czech 
+42 (0) 722 066 591 
www.kasmir.cz

**SZCZECIN, POLAND** 
ГОБИ КАՏՄԻՐ 
Wyzwolenia str, 44 71-500 Szczecin, Poland

## NORTH AMERICA

**WASHINGTON, USA** 
T & U MONGOLIAN CASHMERE 
1663 Wisconsin Ave NW, Washington, USA

**CHICAGO, USA** 
TENGR CASHMERE 
1650, Premium Outlet blvd Suite #981 Aurora, IL 65502-2901, USA

**LIVERMORE, USA** 
3080 Livermore outlets Drive. Livermore. CA94551, USA

**CABAZON, USA** 
48650 Seminole Drive. Suite 184A, Cabazon CA92230, USA (951) 849-5018

## RUSSIA

**MOSCOW, RUSSIA** 
МАГАЗИН ЖЕТЕМ 
Москва, ул. Красного Маяка д. 2Б, ТРЦ “Пражский Пассаж”, 2 этаж, у эскапатора 
+4 957 218 220

**MOSCOW, RUSSIA** 
МАГАЗИН ЖЕТЕМ 
Москва, ул.1-я Останкинская д.53, ТК “Рапира XXI” 2 этаж, пав. 35 Г 
+4 956 096 818

**MOSCOW, RUSSIA** 
МАГАЗИН ЖЕТЕМ 
г. Сочи, курорт “Роза Хутор”, набережная Панорама д. 1

**MOSCOW, RUSSIA** 
МАГАЗИН ЖЕТЕМ 
Долгопрудный, Лихачовский пр-т, д. 64, ТЦ “Конфитюр” магазин, пав. 36, 
+4 987 251 156

**MOSCOW, RUSSIA** 
МАГАЗИН ЖЕТЕМ 
м. Семеновская, Семеновская площадь, д. 1, ТРЦ “Семеновский” павильон 226

**KHIMKI, RUSSIA** 
МАГАЗИН ЖЕТЕМ 
ТЦ “Лига”, ш. Ленинградское, вл. 5, Химки, Московская обл., Россия, 125080

**MOSCOW, RUSSIA** 
МАГАЗИНЫ МИР КАШЕМИРА 
Москва, м. Коньково, ул.Профсоюзная, д.126, кор. 2, магазин 114, “Коньково-пассаж” 
+7 495 229 3314

**MOSCOW, RUSSIA** 
МАГАЗИНЫ МИР КАШЕМИРА 
Москва, м. Теплый Стан, Новоясеневский проспект, д. 1, ТРЦ “Спектр”, 1 этаж 
+7 499 550 9374

**MOSCOW, RUSSIA** 
МАГАЗИНЫ МИР КАШЕМИРА 
Москва, м. Калужская, ул. Профсоюзная, д. 61А, ТРЦ “Калужский” 1 этаж 
+7 499 550 0198

**MOSCOW, RUSSIA** 
МАГАЗИНЫ МИР КАШЕМИРА 
Москва, м. Ясенево, Новоясеневский проспект, д. 11, ТРЦ “Золотой Вавилон” 2 этаж 
+7 499 963 5227

**MOSCOW, RUSSIA** 
МАГАЗИНЫ МИР КАШЕМИРА 
Москва, м. Тульская, ул. Большая Тульская, д. 13, ТРЦ «Ереван Плаза» 2 этаж   +7 495 926 11 57

**MOSCOW, RUSSIA** 
МАГАЗИНЫ МИР КАШЕМИРА 
Москва, м. Тверская, ул. Тверская, д. 28, ТЦ «Иван Плаза», 1 этаж 
+7 499 530 15 01

**MOSCOW, RUSSIA** 
КАШЕМИР МОНГОЛИИ 
Москва, ТЦ “Золотой Вавилон”, г. Москва, м. Отрадное, ул. Декабристов, д. 12, 1 этаж 
+7 499 650 8349

**MOSCOW, RUSSIA** 
КАШЕМИР МОНГОЛИИ 
Москва, м. Ленинский проспект, Ленинский проспект, д. 34/1 
+7 499 135 0081

**MOSCOW, RUSSIA** 
КАШЕМИР МОНГОЛИИ 
Москва, м.Академическая, ул. Профсоюзная, д.16/10, 1 этаж (вход со стороны ул. Кедрова) 
+7 499 530 15 01

**MOSCOW, RUSSIA**

МАГАЗИНЫ WOOLSPIRIT 
WOOLSPIRIT 
М. Китай–Город ул. Маросейка, 13, вход с Лубянского проезда

**MOSCOW, RUSSIA** 
WOOLSPIRIT 
Москва, м. Маяковская, 4-я Тверская-Ямская ул., д. 23, стр.1 
+7 499 250 5116

**MOSCOW, RUSSIA** 
WOOLSPIRIT 
Москва, М. Пушкинская, Чеховская, Страстной бульвар, д. 12, стр. 1 
+7 495 210 0274

**MOSCOW, RUSSIA** 
WOOLSPIRIT 
Москва, м. Смоленская (Арбатско–Покровская линия) Москва, Троилинский пер., дом 3, БЦ”Смоленка”, 3 этаж (на лифте) офис 303 
+7 916 630 8595

**MOSCOW, RUSSIA** 
WOOLSPIRIT 
Мосъва, м. Кузнецкий Мост, Москва, Рождественка 5/7 стр. 1, 2 этаж 
+7 495 625 9532

**MOSCOW, RUSSIA** 
WOOLSPIRIT 
Москва, м. Баррикадная, ул Конюшская, д. 30 
+7 499 252 4277

**MOSCOW, RUSSIA** 
GOBI 
Москва, м. Чистые пруды, ул. Мясницкая, 19 “Чайный дом” 2 этаж 
+7 495 784 0999

**MOSCOW, RUSSIA** 
GOBI 
Москва, м. Новокузнецкое–Третьяковское , Клементовский переулок, дом 6 
+7 495 784 0999

**KAZAN, TATARSTAN, RUSSIA** 
GOBI MONGOLIAN CASHMERE 
ул.Н.Ершова, д.1А, ГРК “КОРСТОН”, Казань, Татарстан, Россия

**KAZAN, TATARSTAN, RUSSIA** 
GOBI MONGOLIAN CASHMERE 
Ул, Джержинского д.5, Казань, Респ, Татарстан, Россия

**ULAN-UDE, RUSSIA** 
МАГАЗИНЫ КАШЕМИР ХАУС 
Ул Ленина 44, Улан-Удэ, Респ, Бурятия, Россия, 670000 
+7 964 414 78 88

**IRKUTSK, RUSSIA** 
МАГАЗИНЫ КАШЕМИР ХАУС 
Ул.Советская 3, Деловой Центр, остановка театр кукоп, Иркутская обл., Россия, 670000 
+7 952 629 29 84

**NOVOSIBIRSK, RUSSIA** 
МАГАЗИН “GOBI” 
Новосибирск, ул. Вокзальная тагисраль 10/1 Торговый центр “ Бонанза” 
+7 913 001 66 21

**OMSK, RUSSIA** 
МАГАЗИН “GOBI” 
Омск, ТВЦ”Каскад, ул.Карла Маркса 24, 1 этаж, бутик 11 
+7 905 097 01 10

**KHABAROVSK, RUSSIA** 
МАГАЗИН “GOBI” 
Хабаровск, ул. Муравьева-Амурского, стр.7, 3 этаж 
+8 914 158 77 06


**SAINT PETERBURG, RUSSIA** 
МАГАЗИН “GOBI” 
Невский проспект 48, Торговый дом – “Пассаж” 
+7 921 321 32 68

**YEKATERINBURG, RUSSIA** 
МАГАЗИН ЭКЗОТИЧЕСКИЙ ТРИКОТАЖ 
Екатеринбург, Пр. Ленина 50, ТК “СитиЦентр” 
+7 343 291 0097

**YEKATERINBURG, RUSSIA** 
МАГАЗИН ЭКЗОТИЧЕСКИЙ ТРИКОТАЖ 
Екатеринбург, ул.Халтурина 55а, ТЦ “Карнавал”, 2 эт., бутик В25 
+7 343 310 1490

**YEKATERINBURG, RUSSIA** 
МАГАЗИН ЭКЗОТИЧЕСКИЙ ТРИКОТАЖ 
Екатеринбург, ул. Красноармейская, 78-а 
+7 343 261 3457

**YEKATERINBURG, RUSSIA** 
МАГАЗИН ЭКЗОТИЧЕСКИЙ ТРИКОТАЖ 
Екатеринбург, ТЦ“БУМ”, ул. Вайнера 19, 2 этаж 
+7 343 376 4246



# **GOBI**

МОНГОЛИАН КАСМЕРЕ

"Говь" ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул дүүрэг,  
Улаанбаатар-17062, Монгол Улс, Ш/Х 36/434

Утас: +976 7013-9977, Факс: +976 7014-3081  
И-мэйл: [info@gobi.mn](mailto:info@gobi.mn)